



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

“Иргэн таныг сонсьё” өдөрлөгийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн өртөө, зөрлөгийн шугам замын иргэд болон малчин, мал бүхий иргэдэд төрийн бодлого шийдвэрийг танилцуулах, байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, иргэдийн санал, хүсэлтийг бодлого шийдвэрт тусгах зорилгоор “Иргэн таныг сонсьё” өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Хангай зөрлөгт зохион байгуулсугай.


2. “Иргэн таныг сонсьё” өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, хөтөлбөрийг гуравдугаар, шаардагдах хөрөнгийн төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус арга хэмжээнд зарцуулагдах 99,400 (Ерөн есөн мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Өдөрлөгт аж ахуйн нэгж, байгууллагууд оролцоогоо бүрэн хангаж, үйл ажиллагаагаа шинэлэг хэлбэрээр сурталчлах, иргэдээс гарсан санал, санаачилгыг ажил хэрэг болгон үйл ажиллагаандаа тусгаж ажиллахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.


5. Дээрх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг тооцон, эргэн танилцуулахыг Ажлын хэсэг (Х.Цогцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дүгээр сарын 09-ны өдрийн
А/05 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“ИРГЭН ТАНЫГ СОНСЪЁ” ӨДӨРЛӨГИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Цогцэцэг	Засаг даргын орлогч
Гишүүд:	Г.Дагвадорж Л.Санжийжамц Н.Нямзав Б.Батзориг Б.Баяртуяа Б.Цогбадрах Т.Лхагвасүрэн Д.Энхтайван Д.Оюунгэрэл Ш.Баасансүрэн М.Уранцэцэг Х.Анхбаяр Ч.Магадсайхан Д.Шүрэн-Эрдэнэ Х.Ганбат Д.Ууганбаатар Н.Насанжаргал Б.Гэрэлмаа Ч.Батхуяг Б.Алтанцоож Ц.Жамбалцэрэн Л.Доржпагма	Дүүргийн менежер Засаг даргын Тамгын газрын дарга Нэгдүгээр хорооны Засаг дарга Хоёрдугаар хорооны Засаг дарга Нийгмийн даатгалын газрын дарга Онцгой байдлын хэлтсийн дарга Цагдаагийн хэлтсийн дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Боловсролын хэлтсийн дарга Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Татварын хэлтсийн дарга Газар зохион байгуулалтын албаны дарга Мал эмнэлгийн тасгийн дарга Эрүүл мэндийн төвийн дарга Багахангай Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч “Насан туршийн суралцахуйн төв”-ийн захирал “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал Соёлын ордны захирал “Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ий захирал “Хэнз хонгор” ХХК-ий захирал
Нарийн бичгийн дарга:	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дүгээр сарын 27-ны өдрийн
А/95 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



“ИРГЭН ТАНЫГ СОНСЪЁ” ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго:

“Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг өртөө зөрлөг, шугам замын иргэдэд сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг сонсон, бодлого шийдвэрт тусгахад оршино.

Зорилт:

1. Дүүрэгт хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний мэдээллийг иргэдэд хүргэх
2. **Дүүргийн хөгжлийн бодлого, дагуул хотын талаарх мэдээллийг танилцуулах**
3. Дүүргийн нутгийн захиргааны байгууллага бүр явуулж буй бодлого, чиглэл, үйл ажиллагаагаа оршин суугч иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлан мэдээлэх
4. Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, санал хүсэлтийг дүүргийн бодлого шийдвэрт тусгах
5. Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг иргэдэд таниулан, сурталчлах
6. Иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх

Хамрах хүрээ: Дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өртөө, зөрлөгийн шугам замын иргэд болон малчин, мал бүхий иргэд

Хугацаа, байршил:

2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 10.00-14.00 цагт Багахангай дүүргийн 2-р хороо, Хангай зөрлөгт

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



**“ИРГЭН ТАНЫГ СОНСЪЁ”
ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР**

№	Үйл ажиллагааны дараалал	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Оролцогч, аж ахуйн нэгж байгууллагуудыг бүртгэх	10.00-11.00	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гэрэлцолмон
2.	Өдөрлөгийн арга хэмжээг нээх	11.00-11.10	Засаг дарга А.Сүхболд
3.	Хөрөнгө оруулалтын ажлын талаарх мэдээлэл	11.10-11.20	Дүүргийн менежер Г.Дагвадорж
4.	Дүүргийн хөгжлийн бодлого, дагуул хотын талаарх мэдээлэл	11.20-11.30	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц
5.	Урлагийн арга хэмжээ	11.30-13.00	Соёлын ордон
6.	Аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны талаарх шторк	13.00-14.00	ААНБ-ууд
7.	Иргэдийн санал хүсэлтийг сонсох, холбогдох тайлбар мэдээллийг өгөх	13.00-14.00	Иргэд Удирдлагууд ААНБ-ууд

ЭЛИЙН Багахангай дүүргийн
5 оны 20... дүгээр сарын 4
гаар захирамжийн дөрөвд

“ИРГЭН ТАНЫГ СОНСЪЁ” ӨДӨРЛӨГТ ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Тайз, дэлгэц зөөвөрлөх (Түлш)	л	20	3200	64,000
2	Эрүүл мэндийн төвийн автомашин (Бензин)	л	15	2360	35,400
	Нийт дүн				99,400